

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2023/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл	
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал.....	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
5. Аудитын илрүүлэлт	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 329

танай _____ -ны № _____ -т

ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ж.ЁНДОНЖАМЦ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Аудитын гол асуудал

Дорнод аймгийн Дашбалбар сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор "хангалттай" гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021222

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,107,771.3	1,373,884.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	722,790.8	885,431.2
33	АВЛАГА	176,625.6	266,310.9
35	БАРАА МАТЕРИАЛ	208,354.9	222,142.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,352,227.8	15,559,033.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,352,227.8	15,559,033.2
39200	Биет хөрөнгө	7,340,630.1	15,547,710.0
39300	Биет бус хөрөнгө	11,597.7	11,323.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,459,999.1	16,932,917.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,459,999.1	16,932,917.8
51	Засгийн газрын хувь оролцоо	8,459,999.1	16,932,917.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	811,835.2	811,835.2
51200	Хуримтлагдсан үр дүн	7,282,434.3	15,755,353.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	365,729.6	365,729.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,459,999.1	16,932,917.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,577,419.2	14,932,449.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,365,931.9	4,089,106.3
110	Орлогын албан татвар	2,568,197.4	3,296,930.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,578,174.5	3,306,911.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,977.2	-9,981.2
113	Хөрөнгийн албан татвар	432,268.0	590,360.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	365,466.6	201,815.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,006,700.5	9,875,803.2
120	Нийтлэг татварын бус орлого	3,689,176.5	9,558,279.2
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	317,524.0	317,524.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,204,786.8	967,540.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,644,213.3	4,440,609.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,644,213.3	4,440,609.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,364,899.6	1,905,589.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,500.5	445,609.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,923.7	52,715.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,082.3	22,295.8
2104	Хангамж, бараа материалын зардал	44,647.5	44,344.9
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,249.6	16,205.8
2107	Томилолт, зочны зардал	8,486.4	15,279.6

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,581.0	443,443.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503,428.6	865,695.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,279,313.7	2,535,020.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,933,205.9	10,491,840.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,255,768.0	2,018,922.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,322,562.1	8,472,918.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,923,813.7	0.0	11,923,813.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-141,252.5	0.0	-141,252.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,782,561.2	0.0	11,782,561.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-3,322,562.1	0.0	-3,322,562.1
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,459,999.1	0.0	8,459,999.1
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,459,999.1	0.0	8,459,999.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,459,999.1	0.0	8,459,999.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	8,472,918.6	0.0	8,472,918.6
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,932,917.8	0.0	16,932,917.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,848,560.2	6,438,234.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,365,931.9	4,089,106.3
110	Орлогын албан татвар	2,568,197.4	3,296,930.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,578,174.5	3,306,911.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,977.2	-9,981.2
113	Хөрөнгийн албан татвар	432,268.0	590,360.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	365,466.6	201,815.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,940.8	8,643.7
1181	Газрын төлбөр	304,602.6	122,909.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	53,923.1	70,262.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,277,841.5	1,381,827.6
120	Нийтлэг татварын бус орлого	960,317.5	1,064,303.6
122	Тусламжийн орлого	317,524.0	317,524.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,204,786.8	967,300.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,419,540.3	4,099,083.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,419,540.3	4,099,083.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,140,226.6	1,563,306.3

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,745.5	491,113.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,442.9	66,379.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,574.0	42,682.4
2104	Хангамж, бараа материалын зардал	110,099.7	109,589.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,954.2	16,205.8
2107	Томилолт, зочны зардал	8,486.4	15,279.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,579.1	279,628.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	265,344.8	542,428.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,279,313.7	2,535,776.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,429,019.9	2,339,151.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,407,731.6	2,008,510.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,407,731.6	2,008,510.8
2200	Дотоод эх үүсвэрээр	1,407,731.6	2,008,510.8
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,407,731.6	-2,008,510.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-168,000.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	168,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,288.3	162,640.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	701,502.6	722,790.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	722,790.8	885,431.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,888,450.7	5,958,174.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,937,788.6	3,774,877.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,402,768.6	1,239,857.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	510,540.7	444,841.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,408.7	52,715.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,362.8	254,603.8
2104	Хангамж, бараа материалын зардал	42,735.0	41,569.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,671.4	29,419.1
2107	Томилолт, зочны зардал	23,154.4	14,199.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,410.2	3,965.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	462,485.4	398,542.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,535,020.0	2,535,020.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,535,020.0	2,535,020.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,535,020.0	2,535,020.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,649,880.4	2,015,297.0
223001	Бусад хөрөнгө	2,649,880.4	2,015,297.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,781.7	168,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	300,781.7	168,000.0

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,888,450.7	5,867,978.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,974,884.2	5,347,131.9
320001	Орон нутгийн төсвөөс	5,105,836.0	4,523,657.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	869,048.2	823,474.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	596,042.5	203,322.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	146,764.4	126,840.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.0	610.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	448,678.1	75,871.3
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	317,524.0	317,524.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	317,524.0	317,524.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	459,914.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	369,718.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,826.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,826.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,125.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	768.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,392.3
2107	Томилолт, зочны зардал	1,080.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,885.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,701.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,701.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	153,826.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,826.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	153,826.3

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 363.6 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 224.6 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 139.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 91.6 хувийн гүйцэтгэлтэй байна. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 224.6 сая төгрөгийн 3 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үүнд: Музейн барилгын ажил -208.7 сая төгрөг, Булаг хаших-5.9 сая төгрөг, Буриад омгийн хонины үүлдрийг хянан баталгаажуулах -10.0 сая төгрөг. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой асуудал

1. 2023 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэл, хүрсэн үр дүнг үнэлж дүгнэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дорнод аймгийн Дашбалбар сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “хангалттай” гэж дүгнэсэн нь бодитой биш байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ нь хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг бодитой дүгнэж байх

2. Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварыг 2021 онд 206.0 сая төгрөг, 2022 онд 227.9 сая төгрөгөөр тооцсон бол тайлант онд 100.3 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь тухайн сумын малын тоонд ногдуулах татварын хэмжээнээс тооцоход татварыг 127.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулах.

3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 11.4 сая төгрөгийн авлагатай байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, журам”-ын 4.7 -д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг барагдуулан ажиллах.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд нийт 132 мэдээлэл оруулахаас худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн хагас жилийн тайлан, 5 саяас дээш орлогын мэдээ гэсэн 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн хагас жилийн тайлан, 5 саяас дээш орлогын мэдээг шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд дэвшүүлсэн зорилтын үр дүнг бодитой үнэлээгүй	1	-					1	-				
Малын татварын орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төлөвлөөгүй	1	127.6					1	127.6				
Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 11.4 сая төгрөгийн авлагатай байна.	1	11.4					1	11.4				
Дүн	3	139.0					3	139.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудсанд 19 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1	-								1	-	
Бусад хууль тогтоомжийн хүрээнд												

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ОНХС-ын 3 арга хэмжээг хэрэгжүүлээгүй	1	224.6			1	224.6		
Нийт дүн	2	224.6			1	224.6	1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 87 ХОНА-2024/02/НА-СТА-ТТЗ
А 1170308

Чойбалсан хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр нийт 2,487.3 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 224.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж, хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дашбалбар сумын Засаг дарга Ж.Ёндонжамц, Санхүү албаны дарга Т.Түмэнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

СЭМЖИДМАА

Б.ОДХҮҮ



011041265